



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2015 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Эрүүл мэнд, спортын яамын харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн  
үндэсний төвийн хэвтүүлэн эмчлэх болон өдрийн эмчилгээний  
орыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 12 дугаар зүйлийн 12.1.3, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.1, Төсвийн тухай хуулийн 16.5.1, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 250 дугаар тушаал, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэнд, спортын сайдын тушаалын дагуу нийгэмд сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал ихээр гарч, өвчлөл ихсэж, тусламж үйлчилгээний хамрах цар хүрээ өсөн нэмэгдэж, хүн амын хэрэгцээнд уялдуулан хэвтүүлэн эмчлэх болон өдрийн эмчилгээний орны шинэчилсэн тоог нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хэвтүүлэн эмчлэх болон өдрийн эмчилгээний орны тоо нэмэгдсэнтэйгээр холбогдуулан клиникүүдэд ажиллах эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн байршлыг дахин төлөвлөхийг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/, Стратеги төлөвлөлт хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг нийт эмч нарын хуралд танилцуулж, хэрэгжүүлэн ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/-д үүрэг болгосугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

00388

СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын  
2015 оны 10 дугаар сарын 09 ны өдрийн  
207 дугаар тушаалын ... хавсралт



**Хэвтүүлэн эмчлэх болон өдрийн эмчилгээний орны шинэчилсэн тоо**

№	Клиникүүд	Орны тоо
1	Сэтгэцийн эмгэг судлалын I клиник	30
2	Сэтгэцийн эмгэг судлалын II клиник	45
3	Сэтгэцийн эмгэг судлалын III клиник	55
4	Сэтгэцийн эмгэг судлалын IV клиник	55
5	Сэтгэцийн эмгэг судлалын V клиник	55
6	Сэтгэцийн эмгэг судлалын VI клиник	45
7	Асрамжийн клиник	125 /45, 45, 35/
8	Яаралтай тусламжийн тасаг	10
9	Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын клиник	35
10	Хүүхэд, өсвөр үеийн клиник	30
11	Донтох эмгэг судлалын клиник	35
12	Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник	30
13	Донтох эмгэгийн эмчилгээний өдрөөр ажиллах	10
14	Сэргээн засах эмчилгээний өдрөөр ажиллах	10
	<b>Нийт</b>	<b>570</b>